

**ГОЛОМТ БАНК ХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/	
Тайлагнах хугацаа	2023.01.01 – 2023.12.31
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	<p>Нэр: Голомт банк ХК</p> <p>РД: 2075377</p> <p>Хаяг: Голомт банкны Төв байр, Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22 Улаанбаатар 15160, Монгол улс</p> <p>Утас: 1800-1646 (24/7) 7011-1646 (Дотуур утас)</p> <p>Факс: 11-313155</p> <p>И-мэйл: mail@golomtbank.com</p> <p>Вэб сайт: golomtbank.com</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	808,657,306 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Тайлан бэлтгэсэн:</p> <p>Э.Тэлмэн /Хөрөнгө оруулалтын менежер/</p> <p>Тайлан хянасан:</p> <p>З.Солонго /ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга/</p>

Тайлант жилийн санхүүгийн тайлан / хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

12/31/2023

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	0.0	0.0
1.1	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	2,236,452,492.6	3,612,907,983.9
1.1.1	Бэлэн мөнгө	101,014,386.6	92,126,134.9
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	1,530,401,568.3	2,297,538,308.9
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	604,672,712.0	1,222,324,220.2
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	363,825.7	919,320.0
1.2	<b>Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө</b>	1,435,169,647.9	1,200,434,798.3
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	357,581,958.6	468,929,954.8
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,076,702,695.9	729,751,167.0
1.2.3	Бусад хөрөнгө	0.0	0.0
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	4,700,591.7	4,162,228.3
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	-3,815,598.4	-2,408,551.7
1.3	<b>Хөрөнгө оруулалт</b>	648,091,787.7	1,180,837,682.5
1.3.1	Арилжааны үнэт цаас	91,754,809.3	107,297,209.3
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	146,689,777.8	579,471,649.7
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	153,265,925.5	194,751,332.3
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	0.0	0.0
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	0.0	0.0
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	222,952,580.0	254,472,103.3
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	24,695,982.1	31,219,464.0
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	8,732,713.1	13,625,924.0
1.4	<b>Зээл (цэвэр дүнгээр)</b>	3,697,633,344.7	4,712,108,704.6
1.4.1	Хэвийн зээл	3,358,379,680.3	4,300,325,085.2
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	221,222,460.3	273,989,445.4
1.4.3	Хэвийн бус зээл	45,764,975.8	29,393,312.6
1.4.4	Эргэлзээтэй зээл	47,430,410.7	34,277,627.1
1.4.5	Муу зээл	171,707,139.0	177,877,379.8
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	-19,565,191.6	-21,837,040.0
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	71,844,229.3	83,274,482.9
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	-199,150,359.2	-165,191,588.4
1.5	<b>Дериватив санхүүгийн хөрөнгө</b>	436,146,109.2	202,386,920.5
1.6	<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	53,204,362.7	52,235,607.2
1.6.1	Бусад санхүүгийн хөрөнгө	12,334,700.4	24,393,872.6
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	13,812,625.8	8,802,866.8
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	6,146,251.5	0.0
1.6.4	Бусад	20,910,785.0	19,038,867.7

1.7	<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>	288,581,708.6	461,282,686.1
1.7.1	Бусад тооцоо	245,962,785.9	421,289,456.8
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	4,470,902.4	4,723,877.2
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	160,633.1	26,922,637.0
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	37,045,069.6	0.0
1.7.5	Татварын авлага	0.0	0.0
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	6,916,322.2
1.7.7	Бусад	942,317.6	1,430,393.0
1.8	<b>Үндсэн хөрөнгө</b>	151,367,641.3	151,082,991.5
1.9	<b>Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө</b>	10,276,475.1	6,586,475.1
1.10	<b>Борлуулах зориулалттай хөрөнгө</b>	6,687,574.6	29,101,737.6
1.11	<b>Биет бус хөрөнгө</b>	20,948,388.0	18,878,648.2
1.12	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	8,984,559,532.3	11,627,844,235.5
2	<b>ӨР ТӨЛБӨР</b>	0.0	0.0
2.1	<b>Харилцах</b>	2,701,602,797.6	3,978,501,265.1
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	2,701,602,797.6	3,978,499,653.1
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	0.0	1,611.9
2.2	<b>Хадгаламж</b>	2,917,007,681.1	3,745,457,557.8
2.2.1	Хугацаагүй хадгаламж	415,285,451.6	514,910,280.3
2.2.2	Хугацаатай хадгаламж	2,403,983,437.1	3,080,407,572.7
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	36,549,073.1	47,386,301.0
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	61,189,719.4	102,753,403.7
2.3	<b>Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр</b>	1,999,288,881.4	2,055,514,237.2
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	136,015,007.8	285,919,785.8
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,862,895,556.4	1,761,250,205.0
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-10,709,024.4	-8,799,485.1
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	11,087,341.5	17,143,731.5
2.4	<b>Бусад эх үүсвэр</b>	306,165,446.8	517,009,311.4
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	0.0	0.0
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	0.0	0.0
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	33,351,388.2	28,890,166.5
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	196,064,993.0	303,440,299.6
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	19,759,217.0	17,164,263.9
2.4.6	Бусад	41,292,200.0	162,080,041.4
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-16,572.3	0.0
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	15,714,221.0	5,434,540.0
2.5	<b>Дериватив санхүүгийн өр төлбөр</b>	0.0	2,890,937.8
2.6	<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>	127,001,773.2	187,688,316.2
2.7	<b>Бусад санхүүгийн бус өр төлбөр</b>	71,587,189.7	69,691,887.3
2.8	<b>Хоёрдогч өглөг</b>	0.0	0.0
2.9	<b>Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)</b>	0.0	0.0
2.10	<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	8,122,653,769.8	10,556,753,512.7
3	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	0.0	0.0
3.1	<b>Хувь нийлүүлсэн хөрөнгө</b>	202,164,326.5	202,164,326.5
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	0.0	0.0
3.1.2	Энгийн хувьцаа	202,164,326.5	202,164,326.5
3.2	<b>Нэмж төлөгдсөн капитал</b>	301,481,120.0	301,481,120.0

3.3	Халаасны хувьцаа	0.0	0.0
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	6,994,662.0	6,666,262.7
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	283,420,820.9	460,718,071.0
3.6	Бусад өөрийн хөрөнгө	67,844,833.1	100,060,942.6
3.6.1	Хувьцааны опцион	847,460.8	0.0
3.6.2	Нөөцийн сан	66,997,372.3	345,396.4
3.6.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	0.0	94,754,925.3
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	0.0	0.0
3.6.6	Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө)	0.0	0.0
3.6.7	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө)	0.0	0.0
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	0.0	0.0
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	0.0	0.0
3.6.10	Бусад	0.0	4,960,620.9
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	861,905,762.5	1,071,090,722.7
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	8,984,559,532.3	11,627,844,235.5

### Орлогын тайлан

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН		12/31/2023 /Мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>Хүүгийн орлого</b>	609,909,165.5	966,457,398.5
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	20,131,191.9	22,961,734.9
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	22,922,861.4	25,015,845.9
1.3	Үнэт цаасны	98,909,162.9	175,446,481.4
1.4	Зээлийн	454,067,741.8	590,666,875.0
1.5	Бусад хүүгийн орлого	13,878,207.6	152,366,461.3
2	<b>Хүүгийн зардал</b>	224,338,381.8	507,708,579.5
2.1	Харилцахад төлсөн хүү	0.0	29,662,945.4
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	163,358,682.3	252,475,567.6
2.3	Зээлийн хүүгийн зардал	57,326,436.8	74,825,704.7
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	0.0	0.0
2.5	Бусад хүүгийн зардал	3,653,262.7	150,744,361.9
3	<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)</b>	385,570,783.7	458,748,818.9
4	<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	49,549,713.1	-27,169,521.1
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	3,584,406.3	0.0
4.2	Үнэт цаасны	-4,181.5	0.0
4.3	Зээлийн	45,969,488.3	-27,169,521.1
5	<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]</b>	336,021,070.6	485,918,340.0
6	<b>Бусад орлого</b>	200,988,399.2	296,005,008.3
6.1	<b>Хүүгийн бус орлого</b>	196,807,806.2	287,692,785.1
6.1.1	Арилжааны орлого	69,242,251.2	182,506,775.0
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	38,154,919.7	1,924,782.4
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	84,131,978.3	103,261,227.8
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	5,278,657.0	0.0
6.2	Бусад орлого, олз	4,180,593.0	8,312,223.2
7	<b>Бусад зардал</b>	343,211,486.1	515,888,252.7
7.1	<b>Хүүгийн бус зардал</b>	324,385,375.7	510,380,923.7
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	103,553,807.2	11,268,700.7

7.1.2	Арилжааны зардал	0.0	1,239,453.5
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	10,071,182.7	240,125,321.5
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	39,961,184.8	58,303,977.4
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	170,799,200.9	199,443,470.7
7.2	Бусад зардал, гарз	18,826,110.4	5,507,329.0
8	<b>Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)</b>	193,797,983.7	266,035,095.5
9	Орлогын татварын зардал	77,295,935.8	56,864,050.6
10	<b>Татварын дараах ашиг, алдагдал (8-9)</b>	116,502,048.0	209,171,045.0
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0.0	0.0
12	<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)</b>	116,502,048.0	209,171,045.0
13	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-38,236,097.2	40,767,083.0
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	0.0	0.0
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	-38,236,097.2	40,767,083.0
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	0.0	0.0
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	0.0	0.0
13.5	Бусад	0.0	0.0
14	<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)</b>	78,265,950.7	249,938,128.0

**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН								12/31/2023
								/Мянган төгрөг/
№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримт-лагдсан ашиг	Нийт Дүн
8	<b>20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	194,739,048.0	169,486,043.9	-9,712,800.0	7,245,102.6	54,468,577.1	242,436,052.6	658,662,024.1
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	194,739,048.0	169,486,043.9	-9,712,800.0	7,245,102.6	54,468,577.1	242,436,052.6	658,662,024.1
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	116,502,048.0	116,502,048.0
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	-38,236,097.2	0.0	-38,236,097.2
5	Өмчид гарсан өөрчлөлт	7,425,278.5	131,995,076.1	9,712,800.0	0.0	51,612,353.3	-75,212,314.7	125,533,193.2
6	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-555,405.5	-555,405.5
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	-250,440.6	0.0	250,440.6	0.0
8	<b>20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	202,164,326.5	301,481,120.0	0.0	6,994,662.0	67,844,833.1	283,420,820.9	861,905,762.5
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	202,164,326.5	301,481,120.0	0.0	6,994,662.0	67,844,833.1	283,420,820.9	861,905,762.5
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	209,171,045.0	209,171,045.0
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	40,767,083.0	0.0	40,767,083.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	-8,550,973.6	8,230,671.1	-320,302.4
6	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	-40,432,865.4	-40,432,865.4
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	-328,399.3	0.0	328,399.3	0.0
8	<b>20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	202,164,326.5	301,481,120.0	0.0	6,666,262.7	100,060,942.6	460,718,071.0	1,071,090,722.7

**Мөнгөн гүйлгээний тайлан**

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН				12/31/2023
				/Мянган төгрөг/
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	193,797,983.7	266,035,095.5	

1.2	<b>Орлого, зардлын тохируулга</b>	<b>-224,600,159.8</b>	<b>-449,290,864.7</b>
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	144,244,638.5	-24,178,292.0
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	33,140,758.8	35,389,742.6
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-31,511,361.7	4,300,803.2
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	609,909,165.5	-840,732,554.7
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	224,338,381.8	363,440,438.5
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	15,096,588.3	12,488,997.7
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	0.0	0.0
1.3	<b>Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга</b>	<b>-503,593,415.2</b>	<b>1,745,128,898.1</b>
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-271,601,331.8	151,987,247.4
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	12,248,807.9	53,309,717.0
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	-567,177,199.6	-1,222,173,620.9
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-79,911,039.4	230,906,299.6
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	26,387,569.9	1,681,232.2
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	284,574,135.7	2,250,057,000.0
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	31,075,728.4	78,475,246.9
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	12,528,795.2	129,223,512.6
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	48,281,118.5	71,662,263.5
1.4	<b>Бусад тохируулга</b>	<b>344,592,187.7</b>	<b>421,912,939.0</b>
1.4.1	Авсан хүү (+)	621,556,128.6	832,609,887.9
1.4.2	Төлсөн хүү (-)	225,243,450.6	-323,631,444.0
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	51,720,490.3	-87,065,504.9
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	0.0	0.0
1.4.5		0.0	0.0
1.5	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-189,803,403.6</b>	<b>1,983,786,067.9</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>8,163,689.5</b>	<b>403,281,102.7</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	508,280.4	8,811,796.6
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	7,516,430.4	3,690,000.0
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	138,978.8	390,779,306.1
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	0.0	0.0
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	0.0	0.0

2.1.10	Бусад мөнгөн орлого	0.0	0.0
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>372,564,556.3</b>	<b>-1,054,028,652.9</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,121,361.5	30,553,696.3
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,162,995.2	4,299,094.9
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	112,280,199.6	843,094,384.1
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	0.0	36,317.0
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	230,000,000.0	176,045,160.6
2.2.9	Бусад мөнгөн зарлага	0.0	0.0
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-364,400,866.7</b>	<b>-650,747,550.2</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,790,656,881.8</b>	<b>4,557,560,501.3</b>
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	1,201,130,205.5	4,557,560,501.3
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	0.0	0.0
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	165,315,152.9	0.0
3.1.4	Төрөл бүрийн хандив	0.0	0.0
3.1.5	Бусад	424,211,523.4	0.0
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,461,515,119.8</b>	<b>-4,473,590,558.6</b>
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	970,908,033.2	4,422,909,852.6
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	5,758,791.2	10,247,840.5
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	30,659,700.0	0.0
3.2.5	Төлсөн ногдол ашиг	555,405.5	40,432,865.4
3.2.6	Бусад	453,633,189.9	0.0
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>329,141,762.0</b>	<b>83,969,942.8</b>
4	Валютын ханшийн зөрүү	84,779,711.9	-40,552,969.2
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-140,282,796.5</b>	<b>1,376,455,491.3</b>
6	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,376,735,289.1</b>	<b>2,236,452,492.6</b>
7	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,236,452,492.6</b>	<b>3,612,907,983.9</b>



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар-14240,  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайвны өргөн чөлөө 17,  
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101  
Факс: +976 7011 8102  
www.kpmg.com/mn

## Хураангуй Санхүүгийн Тайлангийн Хараат Бүс Аудиторын Тайлан

Голомт Банк Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

### Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Голомт Банк ХК (цаашид "Банк" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн хураангуй ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан болон холбогдох тодруулгаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр, Банкны хавсаргасан хураангуй санхүүгийн тайлан нь Тодруулга 2-д дурдсан үндэслэлийн дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Хураангуй санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү хураангуй санхүүгийн тайлан болон аудитын тайлан нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын тайланг орлох үндэслэл болохгүй.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын тайлан

Бид 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн аудитын тайлангаараа тухайн аудитлагдсан санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол онцлох зүйлсийн талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм.

### Удирдлагын хураангуй санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Тодруулга 2-д дурдсан үндэслэлийн дагуу хураангуй санхүүгийн тайланг бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага болно.

### Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байгаа эсэхийг шалгах Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС") 810 буюу "Хураангуй санхүүгийн тайланд дүгнэлт өгөх гэрээт ажил"-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн бидний дүгнэлтийг агуулж буй аудитын тайланг танилцуулах нь бидний үүрэг хариуцлага юм.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот



Баталгаажуулсан:

Г. Соёлмаа  
Ерөнхий Захирал

Баталсан:

Гүн Пён Шиг  
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд баталгаар хязгаарлагдсан Англи Улсын хувийн компани болно KPMG International Limited-д харьяалагдан бие даасан гишүүн байгууллагуудыг нэгтгэсэн KPMG олон улсын байгууллагын гишүүн юм. Бүх эрх хуулиар хязгаарлагдсан.

1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

2 Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1 Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/




## ИРГЭДИЙН ЗЭЭЛ

₮2.2 их наяд

YTD %: +28%

Зах зээлд эзлэх %

Голомтын зээлд эзлэх %





## ИРГЭДИЙН ЭХ ҮҮСВЭР

₮3.5 их наяд

YTD %: +15%

Зах зээлд эзлэх %

Голомтын депозитод эзлэх %




## АЯН ХӨТӨЛБӨРҮҮД

- УБ хот болон орон нутгийн нийт 19 төрөх эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, шинээр төрж буй үрсийг Голомт банкны харилцагчаа болгох **"NEW BORN II"** аяныг хэрэгжүүллээ. Аяны үр дүнд **3,000 гаруй ээжийг баярлуулж** 1,300 шинэ харилцагчийн **1,700** бүтээгдэхүүний борлуулалт хийлээ.
- Шинэ үеийн хүүхэд залуусыг Голомт банкны ирээдүйн үр ашигтай харилцагч болгох, одоогоос тэдэнд банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэж таниулах **"GENZ LOYALTY"** урамшуулалт хөтөлбөрийг 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү аянд 7-25 насны **69,000 харилцагч** хамрагдлаа.
- Голомт банкны нийт харилцагчдыг идэвхжүүлэх, үнэ цэнтэй лоялал харилцагчдыг нэмэгдүүлэх **"BIG LOYALTY"** урамшуулалт хөтөлбөрийг 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүллээ. Нийт **930,000 харилцагч** хамрагдаж лоялалт оноо, түүнийг дагасан урамшуулалт идэвхтэй хамрагдлаа.



## ДИЖИТАЛ СУВГИЙН ШИНЭ БОЛОМЖУУД


- SocialPay 3.0 шинэчилсэн** хувилбарыг зах зээлд нэвтрүүлэв.
- Монгол улсын банк санхүүгийн салбарт хамгийн **анхны виртуал кредит картыг** гаргалаа.
- Дижитал сувгуудаар **пос барьцаалсан зээл, тэтгэврийн зээл, дижитал зээлийн** үйлчилгээг хурдан шуурхай авах боломжийг нэмлээ.
- Төрийн банк болон Капитрон банктэй хамтран ажиллаж **ATM/CDM-ын шимтгэлийг буурууллаа.**
- Шангри-ла худалдааны төвд **Wechat болон Alipay төлбөрт хүлээн авах** үйлчилгээг нэвтрүүлэв.
- Гар утасны NFC технологийг** ашиглан гар утсаараа карт төлбөрт хүлээн авах цоо **шинэ Софт Пос үйлчилгээг** нэвтрүүлэв.
- Банкны карт, дансны үйлчилгээ болон Төрийн үйлчилгээг багтаасан **Смарт киоск төхөөрөмжийг** зах зээлд нэвтрүүлэв.
- Байгууллагад зориулсан тоон гарын үсгийг** Corporate Gateway үйлчилгээнд нэвтрүүлэв.
- Иргэний интернэт банканд тоон гарын үсэг** нэвтрүүлэв.
- Ко-бренд карт:** Централ Экспресс CU-тэй хамтран "CU Виртуал кредит карт", ШУТИС-тай хамтран "All in one" картыг гаргалаа.



## ЗЭЭЛ

Корпорат: **₮1.4 их наяд**  
YTD %: +18%

Зах зээлд эзлэх %



Голомтын зээлд эзлэх %




ЖДБ: **₮1.2 их наяд**  
YTD %: +28%

## ЭХ ҮҮСВЭР


**₮4.5 их наяд**  
YTD %: +68%



Зах зээлд эзлэх %



Голомтын депозитод эзлэх %



## ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ

- “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд 173 тэрбум төгрөгийн зээл олгосон нь нийт зах зээлд 21%-г эзэлж байна.
- Супермаркет, худалдааны төвийн барилгын санхүүжилтэд зориулж 100 тэрбум төгрөгийн зээл олгож **620 ажлын байр** бий болголоо.
- Худалдагчгүй дэлгүүр **Magic Store вендинг** машины төлбөр тооцоонд хамтран ажиллах, санхүүжилт олгох гэрээ байгуулав.
- “Сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл”-н бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн ба 300 гаруй жижиг дунд аж ахуйн нэгжүүд сүлжээ дэлгүүрээс авах авлагаа барьцаалан эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломж бий боллоо.

620

Ажлын байр



## УУЛ УУРХАЙН САЛБАРТ

- Уул уурхайн томоохон компаниудад зориулж **148 тэрбум төгрөгийн санхүүжилтийг** шинээр олгов.
- Оюутолгойн төсөлд туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчээр** ажиллаж буй харилцагч байгууллагуудад 2023 оны байдлаар 347 удаагийн 188 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгон ажиллалаа.
- Уул уурхайн түүхий эд материалын худалдан авалтад зориулж 7.0 сая ам.доллар буюу 24.1 тэрбум төгрөгтэй тэнцэх SWAP хэлцэл хийж **харилцагчийг ханшийн эрсдэлээс хамгааллаа.**

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- МУ-ын банкны салбарыг тэргүүлэн санхүүжүүлсэн (CO2) ялгарлаа хэмжиж, UNEP FI Хариуцлагатай банкны зарчмын тайланд оруулан, Эрнст энд Янг аудитаар баталгаажуулан, тайлагнав;
- Хариуцлагатай банкны зарчмын дагуу уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтоо тодорхойлов;
- МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл доор ToC холбооноос зохион байгуулсан “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног” олон улсын конвенцын эхний өдрийг буюу “Уур амьсгалын эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг Голомт банк амжилттай зохион байгууллаа;
- Харилцагчдадаа зориулан Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ганцаарчилсан сургалтууд зохион байгуулав.
- Харилцагчийн 1,177 зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэв.
- ToC холбооны “Жендерийн Манлай Байгууллага 2023”-аар шалгарав.



Scope 3 Financed  
emission 624,541  
tnCO2e



2030: 30%  
2050: 50%

PCAF  
Partnering for  
Climate Ambition

2030: 5%  
2050: 10%



## НОГООН ЗЭЭЛ

- Банк ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэв. Нийт 5 төрлийн ногоон зээлийн санал болгож эхлэв.
- Эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөр болон ус, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад зориулан Global Climate Partnership Fund, [WaterEquity](#) нөлөөллийн сангуудтай хамтран зорилтот ногоон зээлийг олгож эхлэв.
- Ногоон зээлийн багц 2022 онд 95.8 тэрбум байсан бол **2023 онд 183.04 тэрбум** төгрөгт хүрч, нийт зээлийн багцын **4.0%-д** хүрлээ.


responsAbility WATEREQUITY

Санхүүгийн гол үзүүлэлтүүд (IFRS)	2019	2020	2021	2022	2023	Өөрчлөлт	
						Дүн	%
<b>Балансын үзүүлэлтүүд (тэрбум ₮)</b>							
Нийт актив	6,643	7,278	7,994	8,985	<b>11,628</b>	2,643	29%
Харилцах, хадгаламж	4,901	5,286	5,464	5,743	<b>8,037</b>	2,293	40%
Цэвэр зээл	3,307	3,031	3,339	3,698	<b>4,712</b>	1,014	27%
Нийт өөрийн хөрөнгө	635	632	659	862	<b>1,071</b>	209	24%
<b>Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (тэрбум ₮)</b>							
Цэвэр хүүгийн орлого	211.9	204.4	282.0	385.6	<b>477.3</b>	91.7	24%
Цэвэр хүүгийн бус орлого	81.0	82.5	48.6	141.7	<b>(23.5)</b>	(165.2)	-117%
Своп-н нөлөө	15.0	14.5	(21.8)	34.7	<b>(133.8)</b>	(168.5)	-485%
Үйл ажиллагааны орлого	292.9	286.9	330.5	527.2	<b>453.8</b>	(73.5)	-14%
Үйл ажиллагааны зардал	122.0	121.0	137.1	175.3	<b>200.2</b>	24.8	14%
Үйл ажиллагааны ашиг	170.9	165.9	193.4	351.9	<b>253.6</b>	(98.3)	-28%
Үйл ажиллагааны ашиг /свопын нөлөөгүй/	155.9	151.4	215.2	317.2	<b>387.4</b>	70.2	22%
Сан, үнэлгээний зардал	146.0	143.4	140.8	158.1	<b>(12.4)</b>	(170.5)	
Татварын өмнөх ашиг	24.9	22.5	52.6	193.8	<b>266.0</b>	72.2	37%
Цэвэр ашиг	16.3	10.4	25.9	116.5	<b>209.2</b>	92.7	80%
<b>Зохистой харьцааны үзүүлэлтүүд*</b>							
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12%	13.5%	14.2%	13.3%	17.6%	<b>15.9%</b>		
1-р зэрэглэлийн ӨХ хүрэлцээ >9% (нөөц 4%)	9.0%	13.8%	13.0%	17.6%	<b>15.9%</b>		
ТТГЧ-н харьцаа >25%	32.6%	40.2%	41.3%	36.3%	<b>38.3%</b>		


\*Монголбанкны тайлангаар

**БАЛАНС (ТЭРБУМ ₮)**

**Нийт зээл (тэрбум ₮)**




**Эх үүсвэр (тэрбум ₮)**




**БҮТЭЦ (%)**

**Нийт зээл (%)**



**Эх үүсвэр (%)**



2.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт


	2023Q1	2023Q2	2023Q3	2023Q4	Limits
<b>Liquidity ratio</b>	36.66%	33.33%	39.02%	38.34%	≥30%
<b>LCR</b>	172.1%	161.5%	133.8%	188.4%	≥100%
<b>NSFR</b>	124.0%	132.8%	120.2%	128.9%	≥100%

Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг Монголбанкнаас 25% гэж тогтоосон байдаг. Голомт банкны хувьд дотооддоо Актив, пассивын бодлогын хүрээнд 2023 онд тус харьцааг 30%-аас дээш хангаж ажиллахаар тогтоосон бөгөөд эдгээр харьцаануудыг 2023 оны турш хангаж ажилласан байна.

Монголбанкны зохистой харьцаанаас гадна Голомт банк нь дотооддоо Базелын хорооноос боловсруулсан хөрвөх чадварын харьцаанууд болох LCR, NSFR-г тогтмол тооцоолж, хянаж явдаг. LCR буюу Liquidity Coverage Ratio нь банканд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд бэлэн мөнгөний хэрэгцээ доод тал нь хуанлийн 30 хоног байгаа эсхийг илэрхийлэх харьцаа үзүүлэлт бөгөөд банк тус харьцааг 2023 онд тогтоосон лимитээс дээгүүр буюу 100%-аас дээш барьж ажилласан байгаа нь банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлээ зохистой түвшинд хангаж ажилласан болохыг илэрхийлж байна. Харин NSFR буюу Net stable funding ratio нь банкны урт хугацааны активын санхүүжилтийг хангах урт хугацааны тогтвортой пассивын хүрэлцээтэй байдлыг илэрхийлэх харьцаа үзүүлэлт ба тус харьцааг мөн 100%-аас дээш хангаж ажилласан нь банкны урт хугацааны хөрвөх чадварын эрсдэл нь зохистой түвшинд байгааг илтгэж байна.

Аливаа хөрвөх чадварын богино хугацааны эрсдэл үүссэн тохиолдолд банк нь эзэмшиж буй ТБҮЦ эсвэл ЗГҮЦ-аа барьцаалж Монголбанк болон бусад арилжааны банкуудаас овернайт репо хэлцэл хийх, богино хугацаат своп хэлцэл хийх замаар төлбөрийн чадвараа хангах боломжтойгоос гадна тодорхой валютын хувьд хэрэгцээ үүссэн тохиолдолд бусад арилжааны банкуудтай харилцан депозит байршуулах замаар эрсдэлээ удирдах боломжтой юм.

2.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл




ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эцсээр эдийн засгийн өсөлт 7.0 хувийн өсөлттэй гарав. Үүний 2.6 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 2.1 хувийг үйлчилгээ, худалдааны салбар, 1.8 хувийг Тээвэр ба агуулахын салбар бүрдүүлсэн. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбар өсөлт үзүүлсэн байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БА ИНФЛЯЦ



Эх сурвалж: Монголбанк


Монгол Банкнаас инфляцыг бууруулах болон төгрөгийн үнэ цэнийг хадгалах зорилгоор бодлогын хүүг 2023 оны турш өндөр хэвээр буюу 13 хувьд хадгалсан ба улсын жилийн инфляц өмнөх оны 13.2 хувиас буурч 7.9 хувьд хүрлээ. 2023 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 26.8 хувьтай гарлаа.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ 2023

Нийт хөрөнгийн зах зээлд эзлэх хувь: 19.4%-с 20.1%-д хүрч өсөв



Нийт зээлийн зах зээлд эзлэх хувь: 17.3%-с 17.5%-д хүрч өсөв



Харилцагчийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь: 18.4%-с 20.0%-д хүрч өсөв

Арилжааны хэмжээ  
**29%**

Онлайн худалдааны гүйлгээний тоо, дүн  
**69%, 45%**  
Q3 2023 байдлаар

Кастодиан банк  
**45%**



Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав

Банк нь 2022-2023 онуудад чанаргүй зээлийн багцаа бууруулж, амжилттай IPO хийснээр **өөрийн хөрөнгө, ашигт ажиллагаагаа сайжруулж чадсан** билээ. Үүнд тулгуурлан банк 2024 он болон түүнээс цааших жилүүдэд **актив, орлогын хэмжээ, ашигт ажиллагааны өсөлтийг шинэ түвшинд хүргэж** салбартаа хоёр дахь том мөн ашигт ажиллагаагаараа хоёр дахь банк болох зорилтыг дэвшүүлж ажиллана. Бид 2024-2026 онд дундаж **өөрийн хөрөнгийн өгөөжийг 20%-аас дээш**, ногдол ашгийн хувьд банкны бизнесийн гүйцэтгэл, боломж, орчин, стратеги зэргийг харгалзан **хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тогтвортой** байлгах зорилт тавьж байна.

2024 оны бизнес төлөвлөгөөний гол чиглэлүүд:

1. Дижиталчлалыг эрэлхийлэх
2. Зээлийн шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, зээлийн удирдлагыг бэхжүүлэх
3. Шинэ зээлийн болон бусад бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх
4. ЖДҮ бизнес болон ритэйл бизнесээ бэхжүүлэх,
5. Тогтвортой санхүүжилтийг дэмжих
6. Урт хугацааны хөрөнгө босгох
7. Хөрөнгийн зах зээлд мэдээллийн ил тод харилцаа холбоог бий болгох

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 00/35 тоот тогтоолоор 2024 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх Банкны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдлаа. Үүнд:

- “**Дижитал шилжилтийн газар**”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Процесс удирдлагын хэлтэс, Дата удирдлагын хэлтэс, Төслийн удирдлагын хэлтэс гэсэн 3 хэлтэстэй байна.
- “**Харилцагчийн бүртгэлийн газар**”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Зээлийн хувийн хэргийн хэлтэс, Харилцагчийн хувийн хэрэг хяналтын хэлтэс, Архив ложистикийн албатай байна.
- “**Зээл цуглуулах газар**”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Утсаар цуглуулах хэлтэс, Биечлэн цуглуулах хэлтэс, Тусгай активын хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Хөрөнгийн менежментийн албатай байна.
- “**Харилцагчийн үйлчилгээний газар**”-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Харилцагчийн үйлчилгээний хэлтэс, Харилцагчийн туршлагын хэлтэс, Гомдлын удирдлагын хэлтэстэй байна.
- “Зээлийн газар”-ын бүтэцэд өөрчлөлт оруулж, “Бизнес процесс менежментийн газар”-ыг татан буулгав. Мөн хэлтэс, албадын түвшинд өөрчлөлтүүдийг оруулж бүтэц зохион байгуулалтыг шинэчлэв.

#### 2.4 Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/

##### Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг.

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго бол харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэрийг бэлэн байлгахад оршино. Баталгаа нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн эрсдэл агуулдаг. Бичиг баримтын болон худалдааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээдэд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл, баталгаа болон аккредитив хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглаагүй хэсгээр Банк зээл олгох үүргийг хүлээдэг. Ашиглаагүй зээлийн шугамын хувьд харилцагч тухайн шугамыг ашигласан тохиолдолд л ашигласан зээлийн нийт хэмжээгээр Банк зээлийн эрсдэлд өртөх магадлалтай.

Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд зээлийн шугам авах эрх үүсдэг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага байдаг.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2023 оны 12 сарын 31</b>
Олгосон санхүүгийн баталгаа	67,081,997
Олгосон гүйцэтгэлийн баталгаа	386,870,682
Аккредитив	322,641,372
Ашиглаагүй зээлийн шугам	569,953,318
<b>Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>1,346,547,369</b>
Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сангийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал	(2,848,492)
<b>Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>1,343,698,877</b>

2.5 Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;

**Бусад зээлийн эх үүсвэр**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>2022 оны 12 сарын 31</b>
<b>(а) Төслийн зээлийн эх үүсвэр</b>		
Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/	358,586,882	491,692,237
Төслийн зээлийн эх үүсвэр /Ам.Доллар/	165,202	222,145
<b>Нийт төслийн зээлийн эх үүсвэр</b>	<b>358,752,084</b>	<b>491,914,382</b>
<b>(б) Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр</b>		
Гадаадын банкнаас авсан эх үүсвэр /Ам.Доллар/	955,190,880	1,404,347,293
<b>(в) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт</b>		
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Ам.Доллар/	94,221,889	4,489,570
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Евро/	461,538	12,018,424
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Юань/	2,302,331	3,542,423
<b>Нийт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр</b>	<b>1,052,176,638</b>	<b>1,424,397,710</b>
<b>Нийт дүн</b>	<b>1,410,928,722</b>	<b>1,916,312,092</b>

**(а) Төслийн зээлийн эх үүсвэр**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>2022 оны 12 сарын 31</b>
<b>Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр</b>		
Орон сууцжуулах хөтөлбөр	258,092,912	330,298,612
Шатахууны нөөц бүрдүүлэх хөтөлбөр	54,930,001	86,094,425
Алт 2 хөтөлбөр	16,501,796	41,551,434
КФВ банкны төслийн эх үүсвэр	312,800	576,307
<b>Монгол Улсын Засгийн Газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл</b>		
Жижиг, дунд бизнесийг дэмжих төслийн эх үүсвэр	7,431,219	5,779,061
<b>Азийн хөгжлийн банк болон зээлийн батлан даалтын сангийн төсөл</b>		
Жижиг, дунд бизнесийг дэмжих төслийн эх үүсвэр	2,849,449	2,522,545
<b>Засгийн газрын бусад төсөл</b>		
Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	17,722,166	24,864,743
Бусад төслийн эх үүсвэр	165,202	222,145
Жижиг, дунд бизнесийг дэмжих төслийн эх үүсвэр	743,560	-
Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	2,979	5,110
<b>Нийт төслийн зээлийн эх үүсвэр</b>	<b>358,752,084</b>	<b>491,914,382</b>

Эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн Газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг зорилтод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүгийн хувь нь бага буюу Банкны өөр зээлдэгчдээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг.

Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүгийн хувь нь бага буюу Банкны өөр зээлдэгчдээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр бусад зээлийн эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 2%-аас 12%-ийн хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 6%-аас 25.2%-ийн хүүтэй. Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх эсэхийг авч үзсэн ба тусгай зах зээлийн үндсэн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болох харилцагчид олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарз бүртгэгдэхгүй гэж үзсэн.

Томоохон төсөл хөтөлбөрүүдэд Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарт (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтүүд багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурдвал:



Орон сууцны зээлийг санхүүжүүлэх Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Банк 2014 оноос хойш жилийн 1%, 2%, 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30% тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад бусад банкин дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүдийг дахин санхүүжүүлэх боломжтой зээлүүд багтана.

Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан зээлдэгч нарт жилийн 5%, 6%, 8%-ийн хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүгийн түвшинг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тодорхойлох эрхгүй. Зээлийн олголт болон 6%-ийн хүүтэй олгосон зээлийн дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2023 онд Банк Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-ын хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2026 оны 7 дугаар сарын 17-ны өдөр дуусах хугацаатайгаар хүүгүй санхүүжилт авсан бөгөөд компаниудад 3%-ийн хүүтэй зээл олгосон. Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2021 онд Монгол Улсын шатахууны нөөцийг бүрдүүлэх, шатахуун нийлүүлэгч компаниудыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас санхүүжүүлсэн шинэ хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусах хугацаатайгаар жилийн 6-14%-ийн хүүтэй санхүүжилт авсан бөгөөд компаниудад жилийн 9-17%-ийн хөнгөлөлттэй хүүтэй зээл олгосон. Банк бүх зээлийн олголтыг хэлэлцэж батлах ба зээлийн эрсдэлийг хариуцна.

2020 онд Монголбанкнаас санхүүжүүлж буй “Алт-2” хөтөлбөр нь алт олборлож буй компаниудыг санхүүжүүлэх, Монголбанкны валютын нөөцийг нэмэгдүүлэхэд зориулагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6-12%-ийн хүүтэй санхүүжилт авсан. Санхүүжилтын хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байгаа бөгөөд уул уурхайн компаниудад жилийн 9-15%-ийн хүүтэй зээлийг олгосон.

2012 оноос хойш Банк нь аж ахуйн нэгжүүдэд жижиг дунд үйлдвэрлэлийн ажлын байрыг дэмжихэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих KfW хөтөлбөрт хамрагдсан. Банк нь Монголбанкнаас санхүүжилтийг жилийн 5%-ийн хүүтэй 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр дуусах нөхцөлтэй авсан. Энэхүү гэрээнд Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2011 онд ЖАЙКА-аас жилийн 2%-ийн хүүтэй зээл авсан. Төслийн зорилго нь жижиг дунд бизнесийг болон байгаль орчныг хамгаалах төслийг дэмжих юм. Хөтөлбөрийн дагуу Банк 2033 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл жилийн 2%-ийн хүүтэй санхүүжилтийг авсан бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчдэд жилийн 6%-ийн хүүтэй зээлийг олгосон.

2021 онд Банк Азийн хөгжлийн банкнаас жилийн 5%-ийн хүүтэй зээл авсан. Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй Зээлийн батлан даалтын сантай хамтарсан төсөл нь урт хугацаанд жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг дэмжих зорилготой юм. Банк нь баталгааны хувиас хамаарч 8.88-12.34% -ийн хүүтэй зээл олгох боломжтой. Банк болон Зээлийн батлан даалтын сан нь хамтдаа зээл олголтыг шийдэх ба зээлийн эрсдэлийг тус тусдаа хүлээнэ.

2016 онд Банк Азийн хөгжлийн банкнаас жилийн 4.5%-ийн хүүтэй зээл авсан. Төслийн зорилго нь хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийг дэмжихэд оршино. Хөтөлбөрийг 2029 он хүртэл сунгасан бөгөөд Банк 8%-ийн хүүтэй зээл олгох боломжтой. Банк нь зээлийн олголт, дахин санхүүжилтийг бүхэлд нь хэлэлцэж батлах ба зээлийн эрсдэлийг хариуцна.

**(а) Төслийн зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**

Засгийн газрын байгууллагууд, МонголБанк болон олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний нөхцөлийг дараах хүснэгтэнд харуулав:

Ангилал	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2023 оны 12 сарын 31-нээрх зээлийн дүн /тухайн мянган валютаар/	2023 оны 12 сарын 31-нээрх зээлийн дүн /мянган төгрөгөөр/
Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр	Монголбанк	Орон сууцжуулах хөтөлбөр	Төгрөг	4/21/2016	12/31/2024	258,092,912	258,092,912
	Монголбанк	Шатахууны нөөц бүрдүүлэх хөтөлбөр	Төгрөг	12/13/2021	12/28/2024	54,930,001	54,930,001
	Монголбанк	Алт 2 хөтөлбөр	Төгрөг	6/25/2020	11/25/2025	16,501,796	16,501,796
	Монголбанк	КФВ банкны төслийн эх үүсвэр	Төгрөг	6/8/2012	6/25/2025	312,800	312,800
ЗГ болон ЖАЙКА хамтарсан төсөл	ЖАЙКА	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	9/29/2006	10/10/2033	7,431,219	7,431,219
АХБ болон ЗБДС хамтарсан төсөл	Азийн Хөгжлийн Банк	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	3/22/2021	6/20/2031	2,849,449	2,849,449
Засгийн Газрын бусад төсөл	Засгийн Газар	Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	5/5/2016	10/25/2029	17,722,166	17,722,166
	Засгийн Газар	Бусад төслийн эх үүсвэр	Ам.Доллар	10/7/2014	5/1/2027	48	165,202
	Засгийн Газар	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	7/18/2023	7/17/2026	743,560	743,560
	Засгийн Газар	Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	11/30/2016	12/5/2026	2,979	2,979

(б) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр

Гадаадын бусад банкнаас авсан эх үүсвэрт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 12-97 сар хүртэлх хугацаатай, 2,500-100,000 мянган ам.долларын зээл (2022: 5,000-100,000 мянган ам доллар, 12-100 сарын хугацаатай) авсан зээлүүд багтана.

Эдгээр зээлүүдийн 200,000 мянган ам.доллар нь Банкны тухайн банкин дахь харилцах дансаар баталгаажсан.

2023 онд нэмж хэд хэдэн зээл авсан бөгөөд үүнд 12-60 сарын хугацаатай, 45,000 мянган ам.долларын зээлүүд багтана.

(в) Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын худалдааны санхүүжилт

Банк нь өөрийн харилцагчдын худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын банк болон санхүүгийн байгууллагуудаас худалдааны зээлийн шугам авсан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 184,427,134 мянган төгрөг (2022 оны 12 дугаар сарын 31: 121,435,331 мянган төгрөг)-ийн зээлийн шугамыг ашиглаж, мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдад олгосон. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд харилцагчдын гүйлгээг санхүүжүүлэх зорилгоор санхүүжилт олгодог. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 1 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчаас орж ирэх мөнгөн урсгалын хугацаа болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад эргэн төлөх мөнгөн урсгалын хугацаа нь ижил байдаг. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн зөрчилгүй болно.

3.

Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/

#### **2023.02.28-ны өдрийн хурлын шийдвэр**

Хэлэлцсэн асуудал : Бодь Интернэшнл ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай:

Шийдвэр: Гишүүд Бодь Интернэшнл ХХК-д оффис талбай худалдан авах зориулалтаар хөрөнгө оруулалтын зээл олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

#### **2023.04.05-ны өдрийн хурлын шийдвэр**

Хэлэлцсэн асуудал : Хангууд Пропертис ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай:

Шийдвэр: Хангууд Пропертис ХХК-д эх үүсвэргүй чанарын баталгааг олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

#### **2023.05.12-ны өдрийн хурлын шийдвэр**

Хэлэлцсэн асуудал : Өндөр Улаан Трэвел ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Өндөр Улаан Трэвел ХХК-д хөрөнгө оруулалтын зээл олгохыг дэмжив.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

### **2023.05.29-ны өдрийн хурлын шийдвэр**

1. Хэлэлцсэн асуудал : Голомт Капитал ҮЦК ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Хөрөнгийн зах зээлийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсэв. Мэдээлэл гаргаж өгсөний үндсэн дээр тус зээлийг олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

2. Хэлэлцсэн асуудал : Д. Баясгалан-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Д. Баясгалан-д эргэлтийн хөрөнгийн зээл олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

### **2023.10.13-ны өдрийн хурлын шийдвэр**

Хэлэлцсэн асуудал : Бодь Интернэшнл ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Бодь Интернэшнл ХХК-ийн эргэлтийн хөрөнгийн зээлийн хүсэлттэй танилцан олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

### **2023.11.24-ны өдрийн хурлын шийдвэр**

1. Хэлэлцсэн асуудал : Изи Пэй ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Изи Пэй ХХК-ийн албан хэрэгцээний талбай худалдан авах зээлийн хүсэлттэй танилцан олгохыг дэмжив.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

2. Хэлэлцсэн асуудал : Ашид Голомт ББСБ ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Ашид Голомт ББСБ ХХК-ийн Зээлийн шугам авах хүсэлтийг хэлэлцэн олгохыг дэмжив.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

### **2023.12.07-ны өдрийн хурлын шийдвэр**

1. Хэлэлцсэн асуудал : Цэцэнс Майнинг энд Энержи ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Цэцэнс Майнинг энд Энержи ХХК-ийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлттэй танилцан олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

2. Хэлэлцсэн асуудал : Д.Баясгалантай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Д.Баясгалан-д эргэлтийн хөрөнгийн зээл олгохоор шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

### 2023.12.12-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал : Изи Пэй ХХК-д олгох зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Изи Пэй ХХК-ийн бизнесийн талбайн зээлийн хүсэлттэй танилцан олгохыг дэмжив.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

2. Хэлэлцсэн асуудал : Голомт Капитал ХХК-д олгох зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Голомт Капитал ХХК-ийн Зээлийн шугамыг нэмэгдүүлэх хүсэлтийг хэлэлцэн дэмжиж шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

3. Хэлэлцсэн асуудал : Эмбасси Резиденс оффис дахь талбайг худалдах тухай

Шийдвэр : Голомт банк ХК-ийн эзэмшлийн Эмбасси Резиденс оффис дахь талбайг Эмбасси Резиденс ХХК-д худалдахаар шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

### 2023.12.20-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал : Изи Пэй Норбула ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Изи Пэй Норбула ХХК-ийн зээлийн хүсэлттэй танилцан олгохыг дэмжив.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэв.

#### 4. Цалин урамшууллын мэдээлэл

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2023</b>	<b>2022</b>
<b>Ажилчдын зардал дараахаас бүрдэнэ:</b>		
Цалин хөлс, урамшуулал	73,308,483	55,360,029
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	8,845,970	6,780,120
Хувьцаанд суурилсан төлбөр	-	847,461
Ажилчдын тэтгэмж	1,257,480	658,404
Тэтгэврийн сан	345,490	260,466
Ажилчдын сургалт	494,498	466,532
<b>Нийт ажилчдын зардал</b>	<b>84,251,921</b>	<b>64,373,012</b>

Ажилчдын зардлын томоохон өсөлт нь цалин нэмэгдсэнтэй холбоотой.

#### 5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

#### ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг

Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн гуравдугаар бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг Уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их

15 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Ажлын гараагаа 1996 онд Монголын Хөрөнгийн Биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг байгууллагуудад ажиллан эхлүүлж байсан.

2010 оноос “Тойм” сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12 дугаар сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12 дугаар сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн гишүүн Урс Э.Шварценбах**

Урс Э.Шварценбах нь Швейцар улсын Цюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Цюрих, 1972 онд Лондон дахь Юнион банканд ажилласан. 1976 оноос өөрийн бизнесийг эхэлсэн бөгөөд 2000 онд Канад улсын Нова Скотиагийн “St. Francis Xavier” Их сургуулийн Хүндэт доктор цолоор шагнуулсан.

Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1 дүгээр сард Швейцар улсад оршин суугаа ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын хүндэт консулаар өргөмжлөгдсөн.

2011 оноос эхлэн Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат**

Ж.Үнэнбат нь 1985 онд Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг Эдийн засагч, статистикч мэргэжлээр төгсөж 1994 онд АНУ-ын Нью-Йоркийн Колумбын их сургуульд Олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой.

1990 оноос Монголбанканд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996 оноос 2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 1998 оноос 1999 онд Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банканд Монгол Улсын хариуцсан захирал, 2000 оноос 2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2004 оноос 2016 онд Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийг тэнхимийн эрхлэгчээр ажиллаж ирсэн. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийж, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.

2010 онд Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдож, 2020 оноос ТУЗ-ийн гишүүнээр эхлэн ажиллаж байна.

### **ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр**

Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажиллаж байсан арвин туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Тэрээр Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хувьцаа эзэмшигч болсон ба эдгээр 149 цөөнх хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 2012 онд ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн гишүүн О.Ганжолоо**

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт Их Сургуулийг эдийн засгийн онолын чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн. Мөн Их Британийн Нэгдсэн Вант Улс болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй.

Тэрээр ХБНГУ болон Монгол дахь Олон улсын PwC аудитын компанийн салбаруудад ажиллаж байсан ба өмнө нь Бодь Интернэшнл ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай.

О.Ганжолоо нь 2016 оноос 2023 он хүртэл Голомт Файнэншил Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан. 2022 оноос эхлэн Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б.Двайер**

Двайер нь АНУ-ын “Notre Dame” Их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд тус сургуулийн 40,000 гишүүнтэй төгсөгчдийн холбооны ерөнхийлөгчөөр дараалан сонгогдон ажиллаж байсан.

2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор Монголд анх хөл тавьж, Хойд Америкийн Бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан бөгөөд 2007 онд Монголын Бизнесийн Зөвлөлийг үүсгэн байгуулж, 2016 он хүртэл Гүйцэтгэх захирал, 2017 оны дөрөвдүгээр сар хүртэл ТУЗ-ийн Дэд даргаар ажиллаж байсан.

Тэрээр 1970 оноос хойш Швейцарын Нэгдсэн Банкны дэлхий дахины Нэгдэл ба Худалдан авалт хариуцсан захирлаар, Нью-Йорк хотын Вол Стрийт-д байрлалтай санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын банкир хийж байсан арвин туршлагатай

Тэрээр одоо Мандал даатгал ХК, “Mongolian Growth Group”, Монголын Финтек групп болон Сэндли ХК-ийн охин компанид ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажилладаг. Монголын Бизнес Мэдээллийн Сангийн ТУЗ-ийн гишүүний албыг давхар хашиж байна.

2018 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер**

Александр Пикер нь Австри улсын Салзбургийн их сургуулийг бизнес, хуулийн чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн.

Анх 1989 онд ажлын гараагаа одоогийн Австри банкнаас эхлүүлж, “Die ERSTE Bank”, “International Moscow Bank (IMB)”, “Unicredit Bank”, “JSC ATF Bank Hypo Alpe-Adria Bank”, “HBI Bundesholding AG”

зэрэг банкнуудад эрсдэл хариуцсан захирал, үйл ажиллагаа хариуцсан захирал, гүйцэтгэх захирал зэрэг удирдлагын албан тушаалуудад ажиллаж байсан олон жилийн туршлагатай.

Тэрээр 2020 оноос 2023 онд Дэлхийн банкны томоохон төслүүдэд ахлах зөвлөх, Узбекистаны Ипотека банкны хяналтын зөвлөлийн даргын албан тушаалыг хашиж байсан бөгөөд одоогоор Бүгд найрамдах Молдав Улсын “Moldindconbank” банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байна.

Мөн 2021 оноос Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн хараат бус гишүүн Роберт В.Ван Свитен**

Роберт В.Ван Свитен нь Нидерландын Хаант Улсын Лейден их сургууль болон АНУ-ын Колумбын их сургуулийг Хууль зүйн бакалавр, “Chicago Booth” Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ноён Роберт В.ван Свитен нь дэлхийн санхүүгийн зах зээл болон тогтвортой хөгжлийн салбарт гуч гаруй жил ажилласан арвин туршлагатай. Тэрээр Тогтвортой хөгжлийн институцийн хөрөнгө оруулалтын стратегийн талаар зөвлөгөө өгдөг “Route17” фирмийн хамтран үүсгэн байгуулагч, “Serendra Group”-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн Climate Policy Initiative-ийн гишүүн бөгөөд Хонг Бао Медиа Холдингс ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүүгийн хорооны дарга, Сий Ойл Филиппин корпорацийн ТУЗ-ийн гишүүн, Засаглалын хорооны даргаар ажилладаг.

Тэрээр өмнө нь “EMPEA” холбооны (одоогийн GPCA) ерөнхийлөгч, гүйцэтгэх захирлаар, Сингапурын бирж, “Lehman Brothers”, “General Electric”, “ABN Amro” банк зэрэг компаниудад удирдах албан тушаал, болон Азийн хөгжлийн банкны Хувийн секторын хөрөнгийн зах зээлийн хэлтсийн захирлаар ажиллаж байсан.

Тэрээр 2023 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

### **ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго**

З.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател их сургуулийн бакалавр, 2017 онд СЭЗИС-ийн Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

2017 онд Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-аас Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын мастер хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос хойш Голомт банканд ажиллахдаа Гүйцэтгэх захирлын түвшинд Нарийн бичгийн дарга, Туслахын албан тушаал хашиж, 2015 оны есдүгээр сараас хойш Голомт банкны ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

### **Дотоод аудитын газрын захирал А.Туяа**

А.Туяа нь 2008 онд ХУИС-ийн Санхүүгийн удирдлагын бакалавр, 2015 онд Австралийн үндэсний их сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2008-2017 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2017-2019 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст ахлах аудитор, 2019 оноос 2023 онд

Дотоод аудитын газрын Зайны Аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсийн захирлаар тус тус ажилласан бөгөөд 2023 оноос Голомт банкны Дотоод аудитын газрын захирал томилогдон ажиллаж байна.

## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

### **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал**

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 2-р сарын 2-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд 90.96 хувийн ирцтэйгээр танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Хурлын үр дүнд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан.

Шийдвэрүүд:

1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай  
“Голомт банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг олон нийтэд гаргасан 92,463,154 (ерэн хоёр сая дөрвөн зуун жаран гурван мянга нэг зуун тавин дөрөв) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 808,657,306 (найман зуун найман сая зургаан зуун тавин долоон мянга гурван зуун зургаа) ширхэг гаргасан энгийн хувьцаатай буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 202,164,326,500.00 (хоёр зуун хоёр тэрбум нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун хорин зургаан мянга таван зуу) төгрөгөөр тогтоов.
2. Голомт банкны дүрмийг батлах тухай  
“Голомт банк” ХК-ийн дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан төслийн дагуу батлав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай  
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан буюу дор дурдсан нэр дэвшигчдийг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр хугацаатай сонгосугай.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:*

Чүлтэм овогтой Мөнхцэцэг;  
Жигжид овогтой Үнэнбат;  
Шварценбах овогтой Урс Э.;  
Лувсандорж овогтой Болормаа;  
Дагва овогтой Мөнхтөр;  
Очирпүрэв овогтой Ганжолоо;

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:*

Дваер овогтой Жэймс Б.;  
Абэлло овогтой Антонио Л.;  
Пикер овогтой Александр;

### **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал**

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 26-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд 90.03 хувийн ирцтэйгээр танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Хурлын үр дүнд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан.

Шийдвэрүүд:

1. Голомт Банкны 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай  
Голомт банкны 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, түүнийг баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлав.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалингийн төсөв батлах тухай  
“Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалингийн төсвийг хуралд танилцуулсан төслийн дагуу батлав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай  
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2025 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл сонгосугай.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:*

Чүлтэм овогтой Мөнхцэцэг;  
Жигжид овогтой Үнэнбат;



Шварценбах овогтой Урс Э.;  
 Дагва овогтой Мөнхтөр;  
 Очирпүрэв овогтой Ганжолоо;

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:*

Абэлло овогтой Антонио Л.;  
 Дваер овогтой Жэймс Б.;  
 Пикер овогтой Александр;  
 В.Ван Звитен овогтой Роберт;

4. ХЭХ болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын тухай  
 “Голомт банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журмыг хуралд танилцуулсан Шийдвэрийн хавсралт №1, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралт №2-ын дагуу тус тус батлав.

Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах мэдээллүүдийг танилцуулсан.

1. Голомт Банк ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2. Голомт Банк ХК-ийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн-Хөндлөнгийн аудитын дүгнэлт 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Хатагтай  
 Ч.Мөнхцэцэг  
 ТУЗ-ийн дарга



Ноён  
 Урс.Э.Шварценбах  
 ТУЗ-ийн гишүүн



Ноён  
 Д.Мөнхтөр  
 ТУЗ-ийн гишүүн



Ноён  
 Ж.Үнэнбат  
 ТУЗ-ийн  
 гишүүн



Ноён  
 О.Ганжолоо  
 ТУЗ-ийн гишүүн



Ноён  
 Б.Двайер  
 ТУЗ-ийн хараат  
 бус гишүүн



Ноён  
 Александр Пикер  
 ТУЗ-ийн хараат  
 бус гишүүн



Ноён  
 Роберт В.Ван  
 Свитен  
 ТУЗ-ийн Хараат  
 бус гишүүн















З.Солонго  
 ТУЗ-ийн Нарийн  
 Бичгийн дарга



А.Туяа  
 Дотоод аудитын  
 газрын захирал

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:

	Гишүүд	Албан тушаал
Эрсдэлийн удирдлагын хороо	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн
	 Жэймс Б.Двайер*	Хорооны гишүүн

	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Ж. Үнэнбат	Хорооны гишүүн
Аудитын хороо	 Жэймс Б. Двайер*	Хорооны дарга
	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Д. Мөнхтөр	Хорооны гишүүн
	 Роберт В. Ван Свитен*	Хорооны гишүүн
Засаглал, ёс зүй, цалин урамшуулал	 Жэймс Б. Двайер*	Хорооны дарга
	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
Нэр дэвшүүлэх хороо	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В. Ван Свитен*	Хорооны гишүүн



Ч.Мөнхцэцэг

Хорооны гишүүн

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДАГА



Норихико Като  
Гүйцэтгэх захирал



А.Одонбаатар  
Гүйцэтгэх захирлын орлогч



Г.Ганболд  
Ерөнхийлөгч



М.Сайнбилэг  
Мэдээлэл технологи  
хариуцсан захирал



С.Мөнхтуяа  
Санхүүгийн удирдлагын  
газрын захирал



М.Наранхүү  
Зээлийн газрын захирал



Т.Отгон  
Эрсдэлийн удирдлагын  
газрын захирал



Б.Содболор  
Нөөцийн удирдлагын  
газрын захирал



Ц.Байгалмаа  
Иргэдийн банкны газрын  
захирал



Б.Сугар-Эрдэнэ  
Байгууллагын банкны газрын  
захирал



Г.Уянга  
Хүний нөөцийн удирдлагын  
газрын захирал



Н.Очирхуяг  
Маркетинг, олон  
нийттэй харилцах газрын  
захирал



А.Ганчимэг  
Байгууллага хөгжлийн  
газрын захирал



Ё.Пүрэвбат  
Бүртгэл тооцооны газрын  
захирал



Б.Энхзаяа  
Олон улсын банкны газрын  
захирал



Х.Пүрэвдорж  
Захиргааны газрын  
захирал




О.Батцэнгэл  
Мэдээлэл технологийн  
газрын захирал



А.Нямсүрэн  
Харилцагчийн үйлчилгээний  
газрын захирал



Б.Учрал  
Дижитал банкны газрын  
захирал



Ж.Оюун  
Дижитал шилжилтийн  
газрын захирал



Б.Энхтүвшин  
Зээл цуглуулах газрын  
захирал



Г.Мандах  
Харилцагчийн  
бүртгэлийн газрын  
захирал

## 6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

### Эрсдэлийн удирдлага

2023 хувьд Монгол улс гадаад худалдааны тэнцэл эерэг гарч 60 сая тонн давсан нүүрсний экспортыг гүйцэтгэсэн түүхэн жил болж өнгөрсөн ба Монголбанкны зүгээс инфляцыг зорилтод түвшинд хүргэх зорилтын хүрээнд 13.0%-н бодлогын хүүг тогтвортой барьсан жил байлаа. Дотоодын зах зээлийн эерэг үзүүлэлтийн зэрэгцээ гадаад зах зээлийн орчны хүрээнд улс хоорондын мөргөлдөөн даамжирч, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн эрсдэл болоод бусад хөгжингүй орнуудын хувьд инфляцтай тэмцэх зорилтыг баримтлан өндөр бодлогын хүүг баримталсан жил болж өнгөрлөө. Банк нь гаднын болон дотоодын зах зээлийн хүрээнд үүссэн нөхцөл байдалд харилцагч болоод бизнесийн орчинд нөлөөлж болох эрсдэлийг олон улсын аргачлалын дагуу хянаж, хариу арга хэмжээг зохицуулагч байгууллагын бодлогын хүрээнд мөрдлөг болгон хамтран ажиллаа.

Голомт банкны эрсдэлийн засаглалын хүрээнд “Турван шугамын загвар”-ын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан ба зах зээлийн хүндрэл нөхцөлд үүсэж болох эрсдэлийг стресс тестийн үр дүнгээр тодорхойлж, өөрийн хөрөнгийн болоод хөрвөх чадварын дотоод үнэлгээний аргачлал (ICAAP, ILAAP)-ын дагуу нөөц интервалыг тооцож, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд тусган гэрлэн дохионы аргачлалын дагуу тогтолцооны бүрэлдэхүүнийг улам сайжруулан ажиллаж байна.

Эдгээр бодлогын баримт бичгүүд болон аргачлалын үндсэн зорилго нь Голомт банкны санхүүгийн болон санхүүгийн бус урт хугацааны тогтвортой байдлыг бэхжүүлэх, эрсдэлийн зохистой засаглалыг

төлөвшүүлэхэд чиглэдэг бөгөөд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа үүнийг үндсэн эх сурвалж, удирдлага болгон ашигладаг.

“Гурван шугамын аргачлал”-д нийцтэй байдлыг тодорхойлж олон улсын жишгийн дагуу баталж, мөрдөж ажилладаг. Үүнд:

- Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд “**Нэгдүгээр шугам**”-д хамаарна.
- “Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд “**Хоёрдугаар шугам**”-д хамаарна.
- Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд “**Гуравдугаар шугам**”-д хамаарна.

Банк эрсдэлийн таксономид дурдсан эрсдэлүүдийн материаллаг байдалд үндэслэн гол эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрт хязгаарлалт тогтоож ажиллав. Энэхүү хязгаарлалт нь банкны “**Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл**”-д тусгагдаж жил бүр шинэчлэн бадлагддаг.

Түүнчлэн, Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож нэгтгэсэн стресс тестэд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилладаг.

**Стратеги үнэлгээ** – Зах зээлийн нөхцөл байдалд өөрчлөлт гарах, эсвэл өөрчлөлт гарахаар хүлээгдэж буй нөхцөлд банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгөд эрсдэлийн аппетитд хэрхэн нөлөөлөхийг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж дүгнэлт хийж дахин үнэлж стресс тестийн гол төсөөллүүд дээр үндэслэдэг ба үр дүнг дараа жилийн стратеги, бизнесийн төлөвлөгөөг боловсруулалтад тусгаж ажилладаг. Энэхүү хариу арга хэмжээний зохицуулагч байгууллагын бодлого, зохистой хэмжээний хүрээнд мөрдөгдөж боловсруулагддаг.

### **Зах зээлийн эрсдэлийн удирдлага**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж байгаа эрсдэл юм. Хүү, валютын ханш, арилжаа, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаас болон хөрөнгийн үнэ цэний өөрчлөлт эсвэл зах зээлийн тогтворгүй аливаа нэгэн хөдөлгөөнөөс хамаарч банкны нээлттэй байгаа позиц дах зах зээлийн эрсдэл нэмэгддэг.

Тайлант хугацаанд санхүүгийн зах зээлд валютын ханш, хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл гадна болон дотоодын нөхцөл байдлаас үүдэн эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой бодлого хэрэгжүүлж, болзошгүй алдагдлаас хамгаалан эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна.

2023 онд Голомт банк нь нээлттэй гадаад валютын позицыг Монголбанкнаас тогтоосон шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа. Олон улсын хүрээнд цар тахлын дараах инфляцын эсрэг мөнгөний хатуу бодлогын хэрэгжилтийн хүрээнд санхүүгийн болон санхүүгийн бус учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, зохих хязгаар үзүүлэлтүүдийг шинэчлэн баталж ажиллав. Түүнчлэн Актив Пассивын Хорооноос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг “Value at Risk” аргачлалаар тооцож өдөр бүр хяналт тавьдаг бөгөөд харилцагч талуудын болоод улс орны эрсдэлийн зээлжих зэрэглэл, санхүүгийн харьцаа үзүүлэлтэд үндэслэн харилцагч бүрээр лимитийг тодорхойлж ажиллав.

Мөн банк нь Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслийн хүрээнд урт хугацаат своп хэлцлийг байгуулж үүсмэл хэрэгслийн үнэ цэнийг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт “IFRS 9”-н дагуу тайлагнаж ажиллав.

### **Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм.

Тайлант хугацаанд банкны бизнес төлөвлөгөөнд тусгасны дагуу богино болон урт хугацаанд өндөр хөрвөх чадвар бүхий позицыг барих бодлогыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Банкны хөрвөх чадвар 2023 оны турш Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны хүрээнд болон банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хязгаар үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаа.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд болон урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол ашиглан мөрдөж ажиллалаа. Түүнчлэн учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг үнэлж, стресс сценарыг тооцож, тогтмол гүйцэтгэн, үр дүнг шийдвэр гаргалтад ашиглан удирдаж байна. Мөн 2020 онд бид банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан стандартын дагуу банкны хөрвөх чадварын хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал(ILAAP)-ыг нэвтрүүлж үүний хүрээнд цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг тооцож, түүнд үндэслэн банкны эрсдэл даах чадварыг тодорхойлон ажиллаж байна.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, мөрдөж буй

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Банкны нийт гаргасан 808,657,306 ширхэг энгийн хувьцааг 2023 оны 12-р сарын 31 ний байдлаар нийт 19591 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	Голомт Файнэншил Групп ХХК	624,240,527	77.20%
2	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	42,120,816	5.21%
3	Бодь Интернэшнл ХХК	27,661,497	3.42%
4	Голомт Инвестмэнт Лимитэд	20,800,000	2.57%
5	Олон нийт	93,834,466	11.60%
	<b>Нийт</b>	<b>808,657,306</b>	<b>100%</b>

Голомт Файнэншил Групп ХХК	Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцаа болон зарим хувьцаанд хөрвөх зээлүүдийг эзэмшдэг.
Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Вальют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон.
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг.

Голомт Инвестмэнт Лимитэд	Голомт Инвестмэнт Лимитэд нь 2014 онд Монголын анхны томоохон групп компани болох “Бодь интернэшнл” ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.
Олон нийт	Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

**“ГОЛОМТ БАНК ХК” ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

*/2023 оны 12 сарын 31-ны байдлаар/*

**ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх 103,317,524,755 төгрөгөөс үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн:

- Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлуудыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулна;
- Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг ойролцоогоор 790 гаруй тэрбум төгрөгөөр өсгөх боломж бүрдэж, ирээдүйн бизнесийн тогтмол өсөлтийг бий болгох гол суурь болно.

**ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**

Банк 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд анхдагч зах зээлийн арилжаагаар хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,285 төгрөгөөр нийтэд санал болгов. Захиалгын эрэлт өндөр байсан тул олон нийтэд санал болгосон хувьцааны 15 хувьтай тэнцэх хэмжээний буюу 12,060,411 ширхэг хувьцааг нэмэлтээр гаргаж, нийт 118,815,152,890 төгрөгийг /нийт хувьцааны 11.43 хувь/ олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн 118,815,152,890 төгрөгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

**1. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардал: 2.1 тэрбум төгрөг**

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 12 сарын 06-ны өдрийн 1/4659 тоот зөвшөөрлөөр 2022 оны 12 сарын 08-ны өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төвөөр дамжин нийт 118,815,152,890 төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС дагуу үнэт цаас гаргахтай шууд хамаарал бүхий зардлыг ААНОАТ-ын дүнгээр цэвэршүүлэн 2,103,028,206 төгрөгийг хасагдуулж цэвэр 116,712,124,684 төгрөгөөр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

**2. Зээл олголт 116.7 тэрбум төгрөг**

**Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт /Монголбанкны тайлангаар/**

Үзүүлэлт (сая төгрөг)	Difference				
	11/30/2022	12/31/2022	31/12/2023	(12/31/2023-11/30/2022)	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	673,839	811,978	940,109	266,270	40%
Өөрийн хөрөнгө (Ө.Х)	673,839	811,978	940,109	266,270	40%
Эрсдэлээр жигнэсэн актив	4,600,320	4,601,535	5,926,932	1,326,612	29%
I зэрэглэлийн Ө.Х-ийн хүрэлцээ (>9.0%+нөөц 4.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	
Нийт Ө.Х-ийн хүрэлцээ (>12.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	

2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөртэй харьцуулахад банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцох нийт өөрийн хөрөнгө 266.3 тэрбум төгрөгөөр буюу 40 хувиар өсөж 940.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх хугацаанд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 1.21 нэгж хувиар нэмэгдэж банкны эрсдэл даах чадвар сайжирсанаар зээлийн багцын хэмжээг өсгөх боломж бүрдсэн хэвээр байна.

Банк 2022/12/09-өөс 2023/11/10-ны хооронд харилцагчдад нийт 7,854.6 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу эрсдэлтэй активын хамгийн багадаа 13 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай байдаг. Нийт өөрийн хөрөнгийн 11.43 хувийг олон нийтэд нээлттэй хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө эзэлж байх тул дээрх хугацаанд шинээр олгосон зээлийн 116.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн 116.7 тэрбум төгрөгийн зээлийг төлөвлөгөөний дагуу Том аж ахуйн нэгжийн бизнесийн зээлд 43.5 тэрбум /37.3 хувь/, ЖДБ болон иргэдэд олгосон бизнесийн зээлд 30.3 тэрбум /26.0 хувь/, Хэрэглээний зээлд 24.2 тэрбум /20.7 хувь/, Орон сууцны зээлд 18.7 тэрбум /16.0 хувь/ бүтцээр олгоод байна.

**Банк 2023/11/10-ны байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөө бүрэн зарцуулж дуусгалаа.**

## 9. Ногдол ашгийн мэдээлэл

ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо:	2024.02.14
<b>Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:</b>	<b>2024.03.25 /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр/</b>
Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг:	90 төгрөг
Нийт олгох ногдол ашгийн хэмжээ:	72,779,157,540 төгрөг
Зохицуулагч байгууллагаас ногдол ашиг тараах зөвшөөрөл олгосон хугацаа:	2024.04.23
<b>Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан хугацаа:</b>	<b>2024.04.25</b>

## 10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

#### “Өв соёлын голомт” төсөл

Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүдийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр “Өв соёлын голомт” төслийг санаачлан 2022 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллаж эхэлсэн. Төслийн хүрээнд хувийн хэвшлийн байгууллагуудаас анхлан археологийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Монголын түүх, шашин, соёлыг судлахад чухал нөлөө, томоохон дэмжлэг үзүүлж байгаа юм. 2023 онд төслийн эхний ажлууд болох Түргэний балгас-Туулын “Хар Түнэ Орд” дурсгалт газарт археологийн малтлага, Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт “Ингэт толгойн хүн чулуу”-ны хөшөөний судалгааны ажлуудыг амжилттай гүйцэтгэжээ.



## **“OneSky” хүүхэд хөгжлийн байгууллага**

Эх орны ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа эрүүл мэнд, боловсролд анхаарал хандуулж, хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг бөгөөд 2023 оноос хүүхдийн төлөөх сайн үйлсийн ажлуудаа өргөжүүлэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт амьдардаг бага насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжихээр “OneSky” байгууллагатай хамтран ажиллаж байна. “Хүүхэд бүрийн төлөө” уриатай “OneSky” байгууллага нь Вьетнам, Хятад, Хонконг зэрэг орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2018 онд Монголд “Гэр бүлийн төв”-ийг байгуулсан. Тус төвөөр дамжуулан бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдээ ойлгон хүмүүжүүлэх, суралцах боломжуудыг нь нээхэд туслах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухаанд суурилан боловсруулсан хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, хоол тэжээл, орчны аюулгүй байдлын талаарх “Гэр бүлийг чадавхжуулах” цогц сургалт хөтөлбөрүүдэд хүүхдүүд, гэр бүл, эцэг эхчүүдийг үнэ төлбөргүй хамруулах юм.

## **Оюутны тэтгэлэгт хөтөлбөр**

Боловсролыг дэмжигч Голомт банк 2023 онд 19 дэх жилдээ “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн шилдэг 100 оюутнаа тодруулаа. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиудын оюутнуудын дунд өргөн цар хүрээнд зохион зохион байгуулагддаг уг тэтгэлэгт хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй 650 гаруй оюутан материалаа ирүүлж, 4 үе шаттайгаар өрсөлдсөнөөс 100 оюутан шалгарсан юм.

Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт оюутан болсноор тэтгэлгээс гадна мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах, нийгэм рүү чиглэсэн ажлууд хийх, “G-Student” клубт гишүүнээр элсэх, банкны судлаач оюутны багт дадлага, цагийн ажил хийх, цаашлаад ажил, мэргэжлийн карьераа Голомт банкнаас эхлүүлэх зэрэг олон боломжийг бий болгодог.

Голомт банк “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2003 онд анхлан санаачилж, жил бүр уламжлал болгон хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 50 гаруй их, дээд сургуулийн 1700 оюутанд хоёр тэрбум орчим төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

## **“Зүрх мартаггүй” төсөл**

Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Зүрх мартаггүй” төслийг 2020 оноос хойш дэмжин ажиллаж байна. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн юм. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад зүйлсээр дэмжин ажилладаг бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт 18 мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулж, 600 гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийгээд байна.

Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлууд тодорхой хэмжээнд шийдэгдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог 350-360 болгон нэмэгдүүлээд байна.

## **Морин хуурын чуулга**

Голомт банкны хамт олон үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор эх орны онцгой өв соёлын гол төлөөлөл болох Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгчээр 13 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Морин хуурын чуулгын зүгээс дотооддоо төдийгүй дэлхийн тайзнаа нэр хүндээ бататгаж, олон мянган хүний талархлыг хүлээсэн, чанартай уран бүтээлүүдийг эрхлэн гаргаснаас “Playing Love” болон “Novel Melody” зэрэг бүтээлүүд нь олон улсад танигдаад байна. Хоёр байгууллагын хамтын ажиллагааны хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж, нийт 40 орчим томоохон тоглолт хийгээд байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Залаа-Уул Солонго

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

З. А. А.

Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн огноо: 2024.04.30